



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/52

Арвайхээр

2019 оны “Аймгийн тэргүүний баг”
шалгаруулах тухай

Аймгийн Засаг даргын 2009 оны 175 дугаар захирамжаар батлагдсан “Багийн жилийн үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ-үнэлгээ хийх, аймгийн тэргүүний баг шалгаруулан шагнах журам”-ын 3.4, 5.1 дэх заалтыг үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Төрийн анхан шатны үйлчилгээг иргэдэд чанар хүртээмжтэй хүргэж, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг нийгмийн хөгжлийн зорилтуудыг амжилттай биелүүлж ажилласан Арвайхээр сумын “Өлзийт”-ын 4 дүгээр баг, Нарийнтээл сумын “Баянтээг”-ийн 2 дугаар баг, Өлзийт сумын “Яргайт”-ын 3 дугаар багийг 2019 оны “Аймгийн тэргүүний баг”-аар шалгаруулсугай.

2. Аймгийн Тэргүүний багаар шалгарсан баг тус бүрт 400000 (дөрвөн зуун мянга), нийт 1200000 (нэг сая хоёр зуун мянга) төгрөгийг батлагдсан зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Ц.Ганболд/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100103